



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар A/148

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны өрөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн хүснэгтийг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/187 дугаар захирамжаар Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт “Аж ахуйн зориулалттай”-гаар эзэмшүүлсэн Мөрөн сумын 7 дугаар баг Далайван-6 601 тоотод байршилтай 6712014705 нэгж талбарын дугаартай 4400m<sup>2</sup> газрын зориулалтыг өөрчилж, “Төрийн захиргааны байгууллагын зориулалт”-тай болгон үлдсэн 24 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.
2. Газар эзэмшигч “Хөвсгөл аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар” (РД:9070656)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзүл) нарт тус тус зөвшөөрсүгэй.
3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бурдуулэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6711010564